



## ХЭНТИЙ АЙМГИЙН БОР-ӨНДӨР СУМЫН ‘БОР-ӨНДӨР’ БАГА СУРГУУЛИЙН ЗАХИРЛЫН ТУШААЛ

2024 оны 05 сарын 31 өдөр

дугаар 8/21

Бор-Өндөр

Г Тавдугаар ангийн тайлант өдөрлөг  
зохион байгуулах тухай

Боловсролын ерөнхий хуулийн 33 дугаар зүйлийн 33.3.1, 33.3.3, 40 дүгээр зүйлийн 40.1.2 дахь заалт, Боловсролын ерөнхий газрын даргын 2024 оны 05 дугаар сарын 14-ний өдрийн 01/1995 дугаар албан бичгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Сургуулийн тавдугаар ангийн сурагчдын тайлант өдөрлөгийн үйл ажиллагааг 2024 оны 06 дугаар сарын 07-ны өдөр бага боловсрол эзэмшиж, мэдсэн, сурсан авьяасаа тайлагнах хэлбэрээр зохион байгуулсугай.

2. Тайлант өдөрлөгийн үеэр сурагчийн зөвлөл, эцэг эхийн зөвлөлийн санаачилга нэрээр бэлэн мөнгө татах, багшид бэлэг, хандив өгөх, архидан согтуурах, амралт зугаалга зэрэг эцэг эхэд санхүүгийн дарамт учруулах үйл ажиллагаа зохион байгуулахыг хориглосугай.

3. Энэхүү тушаалыг дагаж биелүүлээгүй, зөрчсөн багш, ажилтанд хууль тогтоомжид заасны дагуу арга хэмжээ тооцуулахаар холбогдох албан тушаалтанд уламжлахыг нийгмийн ажилтан (Э.Нарантуяа)-д даалгасугай.

4. Дээрх үйл ажиллагааг чанартай зохион байгуулж, тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг тайлagnаж ажиллахыг сургалтын менежер (М.Нармандах), дотоод хяналтын ахлагч (Л.Ганганмөрөн), нийгмийн ажилтан (Э.Нарантуяа), анги удирдсан багш нарт тус тус үүрэг болгосугай.

ЗАХИРЛЫН АЛБАН ҮҮРГИЙГ  
ТҮР ОРЛООН ГҮЙЦЭТГЭӨЧ Ч.АМАРЖАРГАЛ

